



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 394

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа Эргүүл, хяналт шалгалтын нэгжийн албан ажлын хэрэгцээнд зориулан Агаарын бохирдлын эсрэг сангийн хөрөнгийн эх үүсвэрээр 631,000,000.00 (зургаан зуун гучин нэгэн сая) төгрөгт багтаан 7 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
394 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ЭРГҮҮЛ, ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН НЭГЖИЙН ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ
ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 4164 cc хүртэл	2	113,185,000.00	226,370,000.00
2	Суудлын тоо 12, хөдөлгүүрийн багтаамж 2359 cc хүртэл	3	87,210,000.00	261,630,000.00
3	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 1999 cc хүртэл	1	85,000,000.00	85,000,000.00
4	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 1591 cc хүртэл	1	58,000,000.00	58,000,000.00
	Нийт дүн			631,000,000.00 (зургаан зуун гучин нэгэн сая)